



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrttd.gov.mn, <http://www.mrttd.gov.mn>

2020. 10. 30 № 03/3745
танай _____-ны № _____-т


“МТЗ” ТӨХК, “ГТХЗНТ” УТУГ,
“МИАТ” ТӨХК, “АТУТ” ТӨҮГ,
“ЗТХТ” ТӨҮГ, “БУЯНТ-УХАА” ОУНБ,
“ДЗ” УТУГ-ЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны
“Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй
байдлын жил болгон зарлах тухай” А/01 дугаар
тушаалын хэрэгжилтийг шалгах ажлын
удирдамжийн дагуу хийгдсэн шалгалтын дүнг
үндэслэн гаргасан Зам, тээврийн хөгжлийн сайдын
2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
“Тушаалын хэрэгжилтийг сайжруулах зарим арга
хэмжээний тухай” А/202 дугаар тушаалыг
хүргүүлэв.

Хавсралт: 6 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД



085768



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Тушаалын хэрэгжилтийг сайжруулах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3.3 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 253 дугаар тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай" А/01 дугаар тушаалын хэрэгжилтийг шалгах ажлын удирдамжийн дагуу хийгдсэн шалгалтын дүнг нэгдүгээр хавсралтад дурдсанаар үнэлсүгэй.

2. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаа, хариуцах байгууллага, албан тушаалтны жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


3. Илэрсэн зөрчлийг арилгасан тухай ажлын тайланг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх, цаашид сахилга, хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалтыг харьяа байгууллага бүр дотооддоо зохион байгуулж байхыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгасан талаарх тайланг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.


5. Сахилга, хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хяналт шалгалтыг жил бүр харьяа байгууллагуудад зохион байгуулж, шалгалтын дүнг хэлэлцүүлж, дүгнэлт өгч ажиллаж байхыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

САЙД

Л.ХАЛТАР




Зам, тээврийн хөгжлийн сайдын
2020 оны 10 дугаар сарын 24-д
А/01 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны
“Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай”
А/01 тушаалын хэрэгжилтийг дүгнэсэн
шалгалтын үнэлгээ

№	Байгууллагын нэр	Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн байгууллага, ажилтны дүрэм, ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажлын хариуцлага, сахилга дэг журмыг мөрдөн сахих ажлын хүрээнд хийсэн ажлын үнэлгээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ажлыг эрчимжүүлж, хариуцлага, хяналтыг тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд хийсэн ажлын үнэлгээ	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай” а/01 дугаар тушаалын хэрэгжилтийг үнэлсэн нийт үнэлгээ
1.	ИНЕГ-ын харьяа “Буянт Ухаа” ОУНБ	84	88	86
2.	“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ	82	95	88.5
3.	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ	87,5	75	81,2
4.	Далайн захиргаа	88	82,5	85.25
5.	“Монголын төмөр зам” ТӨХК	85	71	78
6.	“МИАТ” ТӨХК	85	90	87.5
7.	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ	55	95	75
8.	Орхон АТТ,	72	70	71
9.	Дархан АТТ,	73	70	71,5

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2020 оны 10 дугаар сарын 29 өдрийн
А/202 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны
“Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай”
А/01 тушаалын хэрэгжилтийг шалгасан шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах
хугацаа, хариуцах байгууллага, албан тушаалтны жагсаалт

№	Шалгалтаар илэрсэн зөрчлүүд	Хууль, эрх зүйн үндэслэл	Зөрчил арилгах хугацаа	Хариуцах байгууллага,	Хариуцах албан тушаалтан
1.	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын албан хаагчдыг сургах сургалтын 2020 оны төлөвлөгөөнд Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудаар сургалт явуулах талаар тусгаж хэрэгжүүлэх;	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дугаар тушаалын 2.2.5 дах заалт	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон
2.	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын эрх хэмжээний хүрээнд гаргаж буй зарим захиргааны актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх;	Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дах заалт	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон
3.	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ болон аймгийн автотээврийн төвд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг агуулга, эзлэх хувиар нь ангилж дүн шинжилгээ хийж, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэх;	-Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл -Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дугаар тушаалын 2.1.6 дах заалт.	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон

4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтыг зохион байгуулж, шалгалт авч хэвших;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ “МТЗ” ТӨХК Далайн захиргаа “Буянт-Ухаа” ОУНБ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын дарга Р.Буд “МТЗ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Батсүх Далайн захиргааны дарга С.Түвшинтөр “Буянт-Ухаа” ОУНБ-ын захирал Н.Мягмарсүрэн
5.	Аймгийн автотээврийн төвүүд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгцээг тодорхойлсон сургалтын тусгай хөтөлбөр боловсруулж дараа жилийн төсөвт холбогдох зардлыг тусгуулах;	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйл. -Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дугаар тушаалын 2.2.9 дэх заалт.	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон
6.	Аймгийн автотээврийн төвүүдийн бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах. Тухайлбал: Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаа баталдаг байх, чиг үүргийн хүрээнд төвүүдийн дарга тушаал шийдвэрийг гаргаж байх;	Хөдөлмөрийн тухай хуулийн 5.1 дэх заалт	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон
7.	“Орхон” АТТ-ийн иргэдэд үйлчилж буй авто вокзал үйлчилгээний стандарт, шаардлагыг хангаагүй, мөн төвийн албан хаагчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах зориулалтын авто вокзал байхгүйг	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.1.1 дэх заалт	2020.11.20	“АТҮТ” ТӨҮГ	“АТҮТ” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон

	анхаарч "АТҮТ" ТӨҮГ холбогдох арга хэмжээг авч ажиллах				
8.	Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах чиглэлээр аймгийн автотээврийн төвүүд нарийвчилсан төлөвлөгөө баталж мөрдүүлэх;	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дах заалт	2020.11.20	"АТҮТ" ТӨҮГ "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	"АТҮТ" ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын дарга Р.Буд
9.	Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллах;	"Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дугаар тушаалын 2.1.5 дах заалт.	2020.11.20	"АТҮТ" ТӨҮГ	"АТҮТ" ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон
10.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх сургалтын төлөвлөгөөг батлуулж, сургалт зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.4 дэх заалт	2020.11.20	"МТЗ" ТӨХК	"МТЗ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Батсүх
11.	Байгууллага бүр дотооддоо эрсдэлийн үнэлгээ хийж ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалт	2020.11.20	"МТЗ" ТӨХК "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" Далайн захиргаа	"МТЗ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Батсүх "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв"-ийн захирал А.Буяннэмэх Далайн захиргааны дарга С.Түвшинтөр
12.	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дэх заалт	2020.11.20	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын дарга Р.Буд

	хугацаанд нь хариуг өгч шийдвэрлэж байх.				
13.	“Буянт-Ухаа” ОУНБ-аас ХАБЭА-н дотоод хяналтыг сайжруулах ажлын хүрээнд болон холбогдох бусад үүрэг, даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын Дотоод аудитын газраар хянуулж, тайлагнадаг байх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 35.1 дэх заалт	2020.11.20	“Буянт-Ухаа” ОУНБ	“Буянт-Ухаа” ОУНБ-ын захирал Н.Мягмарсүрэн
14.	2020 оны сүүлийн хагас жилийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3 шатны үзлэгийг зохион байгуулах	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дугаар тушаалын 2 дах заалт	2020.12.20	“Буянт-Ухаа” ОУНБ “МТЗ” ТӨХК “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” Далайн захиргаа	“Буянт-Ухаа” ОУНБ-ын захирал Н.Мягмарсүрэн “МТЗ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Батсүх Далайн захиргааны дарга С.Түвшинтөр
15.	Ажил үйлчилгээний явцад үүсэх сөрөг хүчин зүйл нь ажилтны эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа тухай нэгдсэн судалгаа гаргах, эрүүл мэндийн үзлэг хийсэн эмнэлгийн байгууллагаас дүгнэлт, зөвлөмж авч ажиллах, төлөвлөгөө гаргаж ажиллах;	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 253 дугаар тушаалын 1.2 дах заалт	2020.11.20	“Буянт-Ухаа” ОУНБ	“Буянт-Ухаа” ОУНБ-ын захирал Н.Мягмарсүрэн
16.	Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мөрөөр болон ажил үйлчилгээний явцад үүсэх сөрөг хүчин зүйл нь эрүүл мэндэд хэрхэн сөргөөр нөлөөлж байгаа талаар холбогдох судалгааг хийж, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, шалтгаан нөхцөлийг тогтоох түүнээс хамгаалах арга хэмжээ авч, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх,	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 253 дугаар тушаалын 1.2 дах заалт Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж хэвших;	2020.11.20	“Буянт-Ухаа” ОУНБ “МИАТ” ТӨХК	“Буянт-Ухаа” ОУНБ-ын захирал Н.Мягмарсүрэн “МИАТ” ТӨХК-ийн захирал Д.Баттөр